



ДАСАН ЗОХИЦОХ-ИНТЕГРАЦИЙН КУРС нь таныг Чех улсын нийгэмд хурдан, зөв чиглүүлэхэд туслах сургалт юм. Мөн Чех улсын талаарх үндсэн мэдээлэл болон таны үндсэн эрх, үүргийн талаар танилцуулах болно.

Дасан зохицох-интеграцийн курсийг 2021 оны 1-р сарын 1-нээс хойш Чех улсад удаан хугацаагаар эсвэл байнгын оршин суух зөвшөөрөл авсан ЕХ-ны гишүүн бус орнуудын ихэнх гадаад иргэд хамрагдах ёстой. Та оршин суух үнэмлэхээ авснаас хойш 1 жилийн дотор сургалтад хамрагдаж дуусгах ёстой. Хэрэв та сургалтад хамрагдаагүй бол 10,000 крон хүртэл торгуулах боломжтой.

Та эхлээд сургалтад бүртгүүлэх ёстой. <https://frs.gov.cz> цахим хаягаар нэвтэрч бүртгүүлнэ үү. Нийтийн сургалтын төлбөр 1500 крон төлсний дараа, <https://frs.gov.cz> цахим хаягаар орж сургалтын он сар өдрөө сонгон, бүртгүүлэх боломжтой.

! АНХААР ! ТА УРЬДЧИЛАН БҮРТГҮҮЛЭХГҮЙ БОЛ СУРГАЛТАД ХАМРАГДАХ БОЛОМЖГҮЙ.

Сургалтад бүртгүүлэх дэлгэрэнгүй зааврыг эндээс авна үү: <https://www.vitejtevcr.cz/cs/jak-se-prihlasit>

Дасан зохицох-интеграцийн курс нь 4 цагийн бөгөөд чех багш удирдах боловч сонгосон хэл болох - англи, араб, франц, монгол, орос, серб, испани, украин эсвэл вьетнам хэл рүү орчуулагдана.

Дасан зохицох-интеграцийн курсийн хөтөлбөр:

- Чех улсын талаарх үндсэн мэдээлэл
- оршин суух эрхийн тухай хууль тогтоомж
- боловсрол
- ажил эрхлэлт
- бизнес
- эрүүл мэндийн үйлчилгээ
- орон сууц

Сургалт төгссөнийг нотлох баримт нь гэрчилгээ бөгөөд үүнийг та сургалтад оролцсоны төлөө авах болно.

Дасан зохицох-интеграцийн курсийг олон нийтийн болон хувийн гэж хуваагдана. Та манай Усти аймгийн гадаадын иргэдийн интеграцлалыг дэмжих төвд олон нийтийн сургалтад хамрагдах боломжтой. Хувийн сургалтыг ажил олгогч интеграцлалын төвтэй хамтран зохион байгуулдаг.

Та сургалтын талаар дэлгэрэнгүй мэдээллийг дараах холбооснуудаас авах боломжтой: [MVČR](#), [Vítejte v ČR](#).